



# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ᠳᠠᠷᠬᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠰᠤᠷᠭᠤᠭᠤᠯᠢᠶᠢᠨ Өᠮᠨᠥᠬᠡ ᠪᠣᠯᠠᠨ ᠶᠡᠷᠦᠨᠬᠢᠶᠢᠨ ᠪᠣᠯᠣᠪᠰᠢᠷᠣᠯᠤᠨ ᠰᠠᠯᠪᠠᠷᠢᠨ 2023-2024 ᠣᠨᠢ ᠬᠢᠴᠡᠭᠡᠯᠢᠶᠢᠨ ᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠵᠣᠷᠢᠯᠭ᠎ᠠ, ᠵᠣᠷᠢᠯᠲᠤ

**БАТЛАВ**  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙД  
Д.ЭНХ-АМГАЛАН

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН  
2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэг, сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах зорилгыг 2023-2024 оны хичээлийн жилд дэвшүүлж байна.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

- 1.Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх;
- 2.Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэл хангах;
- 3.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг шинэчлэн тогтоож, аймаг, дүүрэг бүрд хоёр хүртэл ахлах сургуулийг 2024-2025 оны хичээлийн жилээс хичээллүүлэх бэлтгэл хангах;
- 4.Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан байршлаас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг, сургуульд хамрагдах хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх;
- 5.Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах;
6. Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн үр чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах;
- 7.Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги, бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг улирал бүр тооцох;
- 8.Цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, үр чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох;

**БАТЛАВ**  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН  
ДАРГА  
С.ЭНХ-АМГАЛАН

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН**

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дэвшүүлэн гаргасан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн зорилго, зорилт”-ыг бүрэн хэрэгжүүлж, орон нутгийн сургалтын байгууллагын менежмент, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Боловсролын багц хуулийн шинэчлэл, хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хот төлөвлөлт, шинэ суурьшлын бүсүүдийн зохион байгуулалттай уялдуулан ерөнхий боловсролын сургуулиудын бүтцийг шинэчлэх;
2. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, цэцэрлэгийн хүүхэд бүрт эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил, хамгаалал, боловсролын цогц үйлчилгээг чанартай хүргэх;
3. Сургууль, цэцэрлэг бүр хамтын оролцоо, үнэлгээ, шинжилгээнд үндэслэн өөрийн онцлог, сурагчдынхаа хэрэгцээ, хүний хөгжилдөө тулгуурласан менежментийн загвар боловруулж хэрэгжүүлэх;  
Үүнтэй уялдуулан БШУГ-ын дэргэд “Боловсролын бодлогын зөвлөл” байгуулан ажиллана.
4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлан хэрэгжүүлж буй “Боловсрол-2032”, “Чадварлаг багш-Дархан” хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж боловсролын чанар, багшийн хөгжилд ахиц гаргах;
5. “Миний сургууль” цогц судалгааг ерөнхий боловсролын сургуулиудад хийж ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах стратегийг жигд хэрэгжүүлэх;
6. Аймгийн “Багш хөгжлийн төв”-ийг багшийн мэргэжил дээшлүүлэх институт хэлбэрээр хөгжүүлж багш нарын мэргэжлийн өсөлт, хөгжлийг орон нутагтаа чанартаа олгох орчин, чадамжийг бүрдүүлэх;
7. Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг дэмжиж, үйл ажиллагааг эрчимжүүлэн, үнэлгээ, судалгаанд үндэслэн багшийг чадавхжуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
8. Төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа үр дүнг индексээр үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хамтын ажиллагааг сайжруулан, хөгжих боломжийг нэмэгдүүлэх.



Улсын  
9  
Сургуулийн  
Мэргэжлийн  
Төв

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дэвшүүлэн гаргасан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн зорилго, зорилт”-ыг бүрэн хэрэгжүүлж, орон нутгийн сургалтын байгууллагын менежмент, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.





## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

1. Боловсролын багц хуулийн шинэчлэл, хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хот төлөвлөлт, шинэ суурьшлын бүсүүдийн зохион байгуулалттай уялдуулан ерөнхий боловсролын сургуулиудын бүтцийг шинэчлэх;
2. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, цэцэрлэгийн хүүхэд бүрт эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил, хамгаалал, боловсролын цогц үйлчилгээг чанартай хүргэх;
3. Сургууль, цэцэрлэг бүр хамтын оролцоо, үнэлгээ, шинжилгээнд үндэслэн өөрийн онцлог, сурагчдынхаа хэрэгцээ, хүний хөгжилдөө тулгуурласан менежментийн загвар боловсруулж хэрэгжүүлэх; Үүнтэй уялдуулан БШУГ-ын дэргэд “Боловсролын бодлогын зөвлөл” байгуулан ажиллана..

ᠳᠠᠷᠬᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠠᠶᠢᠮᠭᠢ ᠰᠤᠷᠭᠤᠭᠤᠯᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠥᠮᠨᠥᠬᠡ ᠪᠣᠯᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠵᠣᠷᠢᠯᠭ᠎ᠠ, ᠵᠣᠷᠢᠯᠲᠤ





## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлан хэрэгжүүлж буй “Боловсрол-2032”, “Чадварлаг багш-Дархан” хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж боловсролын чанар, багшийн хөгжилд ахиц гаргах;

5. “Миний сургууль” цогц судалгааг ерөнхий боловсролын сургуулиудад хийж ялгаатай хэрэгцээтэй бүх хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах стратегийг жигд хэрэгжүүлэх;

6. Аймгийн “Багш хөгжлийн төв”-ийг багшийн мэргэжил дээшлүүлэх институт хэлбэрээр хөгжүүлж багш нарын мэргэжлийн өсөлт, хөгжлийг орон нутагтаа чанартаа олгох орчин, чадамжийг бүрдүүлэх;





## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

7. Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг дэмжиж, үйл ажиллагааг эрчимжүүлэн, үнэлгээ, судалгаанд үндэслэн багшийг чадавхжуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

8. Төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа үр дүнг индексээр үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хамтын ажиллагааг сайжруулан, хөгжих боломжийг нэмэгдүүлэх.